- “Монголын мэдээ” Монголын түүхийг бичнэ -

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,221,393...
ҮСХ-ны өгигдрийн мэдээгээр

2018.08.21. Мягмар. №138 (4988) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongoliinmedeesonin@gmail.com

20 дахь жилдээ Дугаарыг эрхэлсэн Балжирын ӨНӨРТОГТОХ

ХӨНДӨХ СЭДЭВ

ХҮН ХУЛГАЙЛЖ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АМИАА АЛДСАН Ч

УИХ ХУРАЛДСАНГҮЙ

Б.ӨНӨРТОГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

Гүйцэтгэх засаглалын тэргүүнд эрх мэдлээ алдсан улстөрчид хаврын чуулган завсарласнаас хойш тойргоо тойглож, найр наадам хэсч, зарим нь шанага, данх тараасаар зуныг өнгөрүүллээ. Хэлэлцэх хуулийн төсөл, хийх ажил нь овоорчихсон байхад овооны наадам хийж, түрүүлсэн бөх байлах гээд завгүй явж байлаа. Наадамд түрүүлсэн нутгийн бөхдөө “Ланд-200” машин бэлэглэх, уясан хүлгээ уралдуулж хултай айраг зооглох ажлаа УИХ-ын гишүүд маань харин хамгийн сайн гүйцэтгэсэн шүү. Харин төрийн ажил огт ахисангүй. Бүр хөлбөмбөг өшиглөж, морь унаж ч үзлээ, тэд. Хийх юм аа олж ядаж байна. Харин УИХ-ын хийх ёстой ажлыг Ерөнхий сайд өмнөөс нь хийж, хууль зөрчсөн шийдвэр гаргаад сууж байгаа. УИХ-аар хэлэлцэж чөлөөлөх ёстой сайдыг Ерөнхий сайд нь дур мэдэн албан тушаалаас нь огцруулж, Монгол Улсын нэг чухал яам хариуцах эзэнгүй хагас сар болов.

Үргэлжлэл нь III нүүрт

ДОТОР НҮҮРТ

IV НҮҮРТ:

АТГ АВЛИГАЧДЫН ХЭРГИЙГ ИНГЭЖ ШАЛГАДАГ

...Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий 552 хэргийн баримт, материалыг шалгуулахаар иргэд АТГ-т иргэд хандсан гэсэн үг. Харин иргэдээс ирүүлж буй тэрхүү үнэ цэнэтэй материалыг АТГ хэрхэн шалгаж, шийдвэрлэж байгаа нь маш тодорхойгүй үлддэг...

VI НҮҮРТ:

С.ЧИНЗОРИГ: ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭГ 320 МЯНГАН ТӨГРӨГ БОЛГОЖ ШИНЭЧИЛЛЭЭ

...2014 оноос хойш төрийн албан хаагчдын цалинг огт нэмээгүй. Зайлшгүй нэмэх шаардлага байна гэсний үндсэн дээр энэ оны дөрөвдүгээр улиралд төрийн албан хаагчдын цалинг нэмэх эсэх асуудлыг хэлэлцэхээр болоод байна...

ЯРИЛЦАХ ТАНХИМ

С.ЭРДЭНЭ:

ИЙМ ТОМ ЗОВЛОГЫГ ДААХ АРАГ ЯС МАН-Д БАЙГАА БОЛОВ УУ ГЭЖ НАМЫНХАНДАА ХЭЛЖ БАЙСАН

Б.ПҮРЭВЖАВ
b.puujii11@gmail.com

УИХ-ын гишүүн АН-ын дарга С.Эрдэнийг энэ удаагийнхаа “Ярилцах танхим” буландаа урьж ярилцлаа.

Э.Бат-Үүл намаас гарлаа гэж өргөдөл өгөөгүй

-Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль болно. Намууд нэр дэвшигчээ ирэх сарын 04-нөөс өмнө зарлах ёстой. АН хэнийг энэ удаагийн сонгуульд сойх вэ гэдгээс ярилцлагаа эхлэх үү?

-Нөхөн сонгуулийн нэр дэвшилтийн хуулийн хугацаа болоогүй. Мөн хууль эрх зүйн маргаан гаргасан учир Үндсэн хуулийн цэцэд асуудал нь очсон. Манай намын зүгээс нэр дэвшигчээ одоохондоо шийдээгүй байгаа. Энэ талаар ярилцаагүй байна.

-Нөхөн сонгууль нэлээд өрсөлдөөнтэй болох нь. Улс төрийн намуудаас гадна бие даагчид нэр дэвших сурагтай байсан?

-Нөхөн сонгуульд өрсөлдөөн их байна уу, цөөн байна уу гэдэг нь манай намд хамаагүй. Нөхөн сонгуульд оролцоно гэдгээ албан ёсоор мэдэгдсэн. Ач холбогдол нь их байна уу, бага байна уу, өрсөлдөгч олон байна уу, цөөн байна уу гэдэг нь асуудал биш. Үндэсний хэмжээний том намын хувьд сонгуульд оролцоно гэдгээ илэрхийлсэн.

Үргэлжлэл нь V нүүрт

МЭДЭЭЛЭЛ

Хууль бусаар ажиллаж байсан мөрийтэй тоглоомын газрыг илрүүлжээ

Б.ӨНӨРТОГТОХ

Нийслэлийн цагдаагийн газраас гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг болон үйлдэгдэж болзошгүй газруудад "Эмзэг цэг" нэгдсэн арга хэмжээ болон "Эрсдэл хамгаалал" аяныг зохион байгуулж эхэлжээ.

Уг аяны хүрээнд нэг хоногийн хугацаанд гэхэд л 54 алба хаагч 22:00 цагаас өглөөний 06:00 цагийн хооронд эргүүл хяналт шалгалт явуулж 84 иргэн 27 аж ахуй нэгж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байсан 10 дэн буудлын үйл ажиллагааг зогсоож 13 зөрчил илрүүлэн шалгаж байгаа аж.

Энэ талаар Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийн цагдаагийн дэслэгч Т.Отгонбаяр "Нэгдсэн арга хэмжээ эхэлснээс хойш Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэс нийтдээ 33 зөрчил илрүүлж, 7.6 сая төгрөгийн торгууль ногдууллаа. Мөн автомашины эд ангийг хулгайлдаг бүлэг этгээдийг илрүүлж, баримтжуулан цагдаагийн байгууллагад шалгуулахаар өглөө" гэв.

Мөн НЦГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн ахмад А.Энхтуул "Арга хэмжээний хүрээнд Баянгол дүүргийн наймдугаар хорооны нутаг дэвсгэрт хууль бусаар мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлж, үйл ажиллагааг зогсоолоо" гэсэн юм. "Эмзэг цэг" нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэд цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч ажиллах ёстойг ч мөн сануулаа.

НИЙГЭМД ЦӨӨН МӨРӨӨР

• Хичээлийн шинэ жилийн нээлт есдүгээр сарын 1-нд буюу бямба гарагт болно. Харин хичээл есдүгээр сарын 3-нд буюу даваа гарагт эхлэх аж.

• Архангай аймгийн Өндөр-Улаан суманд өнгөрсөн долдугаар сарын 25-нд орсон аадар бороо, мөндрийн улмаас тус сумын 82 айл гэр оронгүй болсон билээ. Гэр оронгүй болсон 37 өрхөд Архангай аймаг дахь "Дэлхийн зөн" олон улсын байгууллагаас гэр олгожээ.

• Энэ сарын 25-ны өдөр буюу Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн залуучуудын хөгжлийн газартай хамтран бүтэн нэг сарыг залуучуудын хөгжлийн сар болгон зарлажээ.

• 2018 оны зургадугаар сарын байдлаар адууны махны экспорт 1.5 дахин их, хонины болон ямааны мах 4.3 дахин их, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн 8.1 дахин их тус тус нэмэгджээ.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Ц.Болорчулуун: Ургацаа 100 хувь хурааж чадвал дотоодын хэрэгцээг бүрэн хангана

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ
ts.chandmanierdene@gmail.com

Ургац хураах цаг болж буй. Тийтээс холбогдуулан ургацын урьдчилсан баланс болон тариалын болц, ургац хураалтын бэлтгэл ажлын талаар ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Болорчулуунаас тодрууллаа.

-ХХААХҮЯ-аас газар тариалангийн салбарт 2018 онд улаан буудай, төмс хүнсний ногоо болон, жимс жимсгэний дотоодын хэрэгцээг бүрэн хангана гэж зорилт дэвшүүлсэн. Ургацын балансаар зорилтдоо хүрч чадаж байна уу?

-Яамны зүгээс 2020 он гэхэд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон улаан буудайн дотоодын хэрэгцээг бүрэн хангана гэдэг зорилт тавьсан. Энэ жилийн хувьд тавдугаар сарын сүүлийн 10 хоногийн цаг агаарын хүндрэлтэй байдлаас шалтгаалж улаан буудайг төлөвлөсөн хэмжээнээс 20 орчим мянган га-гаар дутуу тариалсан. Гэхдээ тариалсан талбайгаас ургацаа 100 хувь хураасан тохиолдолд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангана гэсэн тооцоо гарсан.

-Өнгөрсөн долдугаар сард ихэнх нутгаар бороо их орсны улмаас зарим нуттууд үер усны гамшигт нэрвэгдсэн. Энэ нь газар тариалангийн бүс нутагт, тэр тусмаа ургацын болцод сөргөөр нөлөөлсөн үү?

-Тариалангийн бүс нутгаар хүндрэл гараагүй. Харин ч ургац, хадлангийн талбайн өвсний массыг нэмэгдүүлж бэлчээр сайжирч байна. Бороо ороод нар гараад байсан учир таримлын өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлсөн зүйл байхгүй. Ургацын болц хэвийн явагдаж байгаа.

-Ургацаа хэзээ хурааж дуусгах төлөвлөгөөтэй байгаа вэ?

-Аравдугаар сарын эхний долоо хоногт дуусгана. Цаг агаар мэдээж нөлөөлнө. Техникийн хүчин чадлын хувьд ч ийм боломж бий. Ургац хураалтын оргил үед буюу ес, аравдугаар сард олон жилийн дундажтай ойролцоо хур тунадас унана гэсэн урьдчилсан төлөв гарсан. Байгаль цаг уурын гэнэтийн бэрхшээл тулгарахгүй бол төлөвлөсөн хугацаандаа бүх ажлаа дуусгах боломжтой.

-Газар тариалан эрхлэгчдийн ургац хураалтад төрөөс дэмжлэг үзүүлэх үү?

-Ургац хураахад шатахууны дэмжлэг үзүүлж байгаа. Газар тариалан эрхлэгчид хэдэн га талбайгаас ургац хурааж авах мэдээ судалгаа бидэнд байгаа учраас ААН-үүд хүсэлтээ гаргаад шатахууны дэмжлэгт хамрагдах боломжтой. Дэмжлэг хүссэн байгууллагууд шатахууны үнийн 50 хувийг урьдчилж төлөөд 50 хувийг нь намрын ургацаараа төлөх боломжтой.

-Газар тариалан эрхлэгчдийн парк шинэчлэлтэд төрөөс дэмжлэг үзүүлдэг үү?

-Өнөөдрийн байдлаар газар тариалан эрхлэгчид үр тарианы техникийнхээ 60 орчим хувьд нь парк шинэчлэл хийсэн байгаа. Мөн яамнаас намрын ургац хураалтад зориулж ОХУ-аас 30 ширхэг комбайн оруулж ирсэн. Түүнийгээ ААН-үүдтэй гэрээ байгуулаад олгоод эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 12 компани гэрээгээр комбайн авсан байна. Үлдсэн 28 комбайныг гэрээгээр өгнө. Тариалан эрхлэлтийг дэмжих санд үтрэмийн машин буюу будаа цэвэрлэгээ сортлох машин ирсэн байгаа. Түүнийг мөн л ААН-үүдэд өгч байгаа. Энэ жил БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 24.5 сая долларын усалгааны тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн.

> ...Өнөөдрийн байдлаар газар тариалан эрхлэгчид үр тарианы техникийнхээ 60 орчим хувьд нь парк шинэчлэл хийсэн байгаа. Мөн яамнаас намрын ургац хураалтад зориулж ОХУ-аас 30 ширхэг комбайн оруулж ирсэн. Түүнийгээ ААН-үүдтэй гэрээ байгуулаад олгоод эхэлсэн...

МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд нь бүртгэгдсэн эсэхийг эцэг эхийн гар утсанд мессежээр мэдэгдэнэ

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн цахим бүртгэл долоодугаар сарын 25-наас наймдугаар сарын 23-ны хүртэл үргэлжилнэ. Өчигдрийн байдлаар нийт 76898 хүүхэд цахимаар бүртгүүлжээ. Элсэлт авах хүүхдийн хяналтын тоо хэтэрсэн цэцэрлэгүүдэд энэ сарын 24-ний 09:00 цагаас санамсаргүй түүврийн аргаар цахим системээр элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах аж. Цахим элсэлтийн дүн эцэг, эхчүүдийн бүртгүүлсэн гар утасны дугаарт мессежээр очих юм.

Эцэг, эхчүүд хүүхдээ цэцэрлэгт хамрагдсан эсэхийг мэдэхийн тулд цахим системийн шалгах цэс рүү тухайн өдрийн 10:00 цагаас эхлэн нэвтэрч хүүхдийнхээ бүртгэлийн дугаараар шалгах боломжтой юм.

Харин цахимаар бүртгүүлэх боломжгүй иргэдийн хувьд долоодугаар сарын 25-наас зөвхөн ажлын өдөр 09:00-17:00 цагийн хооронд харьяа дүүргийнхээ Боловсролын хэлтэст бүртгүүлэх боломжтой. Түүнчлэн наймдугаар сарын 13-23-ны хооронд хамран сурах тойргийн цэцэрлэг дээр багш, ажилтнууд цахимаар бүртгүүлэхэд тусалж байгаа тул эцэг, эхчүүд өөрийн биеэр очиж бүртгүүлж болох ажээ.

PHOTO NEWS

Сургууль цэцэрлэг барих газрыг чөлөөлж эхэлжээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

"Улаанбаатар хуурга" шалгаруулах анхдугаар тэмцээн болно

С.БУДРАГЧАА

Энэ сарын 24-26-ны өдрүүдэд Үндэсний соёл амралтын хүрээлэнд "UB Food Festival" арга хэмжээ зургаа дахь жилдээ зохион байгуулагдахаар болжээ. Монгол хоолны соёлыг дотоод гадаадын иргэдэд түгээн дэлгэрүүлэх зорилготой уг өдөрлөгийн үеэр Нийслэлийн нэрийн "Улаанбаатар шөл" болон "Улаанбаатар хуурга" шалгаруулах анхдугаар тэмцээн болох аж.

Өдөрлөгийн үеэр аж ахуйн нэгжүүд хамгийн чанартай, амтлаг нэрийн бүтээгдэхүүн, олон улс үндэстний хоол, зууш амттаныг багасгасан хэмжээтэйгээр бэлтгэж, хямд үнээр иргэдэд борлуулах аж. Мөн гудамжны шилдэг хоолтой газар, шилдэг тогооч нарыг шалгаруулж, үзэгчид дунд "Хэн хамгийн олон хотдог, бургер идэх вэ?", "Аавтайгаа хамт", "Зайрмагны баяр", "Айрагны баяр" зэрэг уралдаан, хөгжөөнт тоглоом, урлаг соёлын хөтөлбөрүүд, хоол урлалын сонирхолтой үзүүлбэрүүдийг зохиох юм байна.

Цэцэрлэгийн багш нар сургалтад хамрагдаж байна

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

"Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог-Сургалтын арга зүй" сэдэвт сургалт Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд өчигдөр нээлтээ хийлээ. Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэн, цэцэрлэгийн арга зүйч 200 гаруй хүн хамрагдаж буй уг сургалт өнөөдөр өндөрлөх юм. Сургалтыг БСШУСЯ-ны Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар, МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Удирдлагын академи, "Хүүхдийг ивээх сан", нийслэлийн түшиц цэцэрлэгүүд хамтран зохион байгуулж байгаа аж.

2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын салбарын хувьд "Сургуулийн өмнөх боловсролын салбарын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах" зорилт дэвшүүлжээ. Энэ хүрээнд тодорхой судалгааны аргачлал, шалгуур үзүүлэлтэд суурилан сургалтын тодорхой арга боловсруулж, хэрэглэх чадварыг цэцэрлэгийн арга зүйчдэд эзэмшүүлэх нь уг сургалтын зорилго ажээ.

"Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог-Сургалтын арга зүй" сургалтын хувьд үндэсний хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж буйгаараа онцлог юм.

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ: Б.ОЮУНГЭРЭЛ

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Н.ПУНЦАГБОЛД 88096454

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД МЭДЭЭЛЛИЙН АЛБА: Б.ПҮРЭВЖАВ 99210031

НИЙГЭМ, ЭРЭН СУРВАЛЖЛАХ, ШУУРХАЙ МЭДЭЭЛЛИЙН АЛБА: С.БУДРАГЧАА 90005522

ЦАХИМ ҮЙЛДВЭРЛЭЛ, САНХҮҮГИЙН АЛБА: Э.САЙНЗАЯА 99197866

МЕНЕЖЕРҮҮД: М.ДАВААДУЛАМ 99042510; Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710; Г.АЛТАНТУЯА 99613084

ФЭЙСБҮҮК: www.facebook.com/mmdardas/ ТВИТТЕР: www.twitter.com/mmdardas

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 210, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-гийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МОНГОЛЫН МЭДЭЭ 2018 оны долдугаар сарын 05. Пүрэв. №133 (4983)

ХӨНДӨХ СЭДЭВ

...Нийслэлийн есөн дүүрэг, 21 аймаг үерийн гамшигт өртөж, хэдэн тэрбумын хохирол амсчихаад байхад ч УИХ-ын гишүүдэд найр наадам л чухал байсан юм. Ядарсан ард түмнээ харин шанага, данх, орос гутлаар хуурчихаад л "улсын ажил унаагүй, улстөрчид бид чинь завгүй ажиллаж байна" гэсэн пиараа хийсээр л байлаа. Ард түмнээс үнэмлэхүй олонхийн эрх авч, 65 суудал авсан тэдний бүрэн эрхийн хугацаа талдаа орчихож. Гэвч амласан мөрийн хөтөлбөр нь хэрэгжсэнгүй...

ХҮН ХУЛГАЙЛЖ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АМИА АЛДСАН Ч УИХ ХУРАЛДСАНГҮЙ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Орны хүнийг хэлэлцэж томилох хуулиар хүлээсэн үүрэгтэй УИХ-ын чуулганы сураг өнөө хэр дуулдсангүй. Албан үүргээ гүйцэтгэж байсан төрийн албан хаагчийг гурван цаг зодож хөнөөдөг хариуцлагагүйн зуд төрд нүүрлэв. 300 гаруй зорчигч тээвэрлэж явсан вагон осолдож, хүний амь эрсдэх шахсан байхад "Надаас болоогүй, үерээс болсон" гэсэн хачин жигтэй тайлбар хийчихээд сууж байна, хурган дарга нар нь. Сонгогчдын итгэлийг хүлээж 65-уулаа үнэмлэхүй олонхи бүрдүүлсэн атлаа дотооддоо хоёр, гурав хуваагдсаны гор ийнхүү хүний алтан амиар төлөгдлөө. Ийм байхад УИХ хийх ажилгүй, хэлэлцэх хуульгүй гэсэн ядмагхан тайлбар өгчихөөд сууж огтхон ч боломгүй санагдах юм. Бүр ирц хүрэхгүй байх гэсэн тайлбарыг ч албаны хүн өгсөн удаатай. Зам тээвэр, хөгжлийн яаманд гарсан энэ харамсалтай хэрэг МАН-ын дотоодын зөрчил хэрхэн туйлдаа хүрснийг гэрчиллээ. Ам дамжсан ярианаас сонсоход талийгаачийг ажлаас нь халах шийдвэр гаргаж, албан өрөөндөө дуудаж ирүүлээд зодож эхэлсэн гэх яриа ч байна. Эндээс л төрийн бүх шатанд бий болсон 32, 33-ын бүлгийн зөрчлийг яруу тодоор харж болно. Харин МАН-ынхан алдааг өөрсдөөсөө холдуулахын тулд амиа алдсан залуугийн талаар сананд оромгүй яриа гаргаж, гэмт хэрэгтнийг сөрөг намын гар хөл байсан мэтээр цуурч, бичиж эхлэв. Хүнээ барсан, жудгаа алдсан ийм арчаагүй пиар явуулах хүртлээ МАН-ынхан зөрчилджээ. Дэгсдүүлж хэлбэл, эрх баригчдын зөрчил төрийн албыг сөхрүүлэв. Төрийн албаны завхарлыг яруу тодоор харуулав. Дахиад хэдэн хүний амийг авч одох ёстой юм бол. Эдийн засгийн хувьд өсөлт нэмэгдэж, өмнөх онуудаас өр шир нь багассан хэмээн Ерөнхий сайд нь эмгэнэл унших зууртаа мэдэгдсэн байлаа ч түүнээс илүүтэй энэ улсын толгойн өвчин болсон засаглалын хямрал гэгч нь жинхэнэ утгаараа бий болсныг найр наадамтай давхацсан хэд хэдэн ноцтой үйлдлүүд баталчихлаа. Туургатусгаар Монгол Улсын нутаг дэвсгэрээр Туркийн тагнуулын онгоц нисч орж ирээд хүн хулгайлахыг завдлаа. Аанай л улстөрчид таг чиг. Үндэсний аюулгүй байдал ямар төвшинд хүрснийг энэ үйл явдал батлан харуулж байхад "хэлэлцэх асуудал байхгүй ээ" гэсэн тайлбартаа бат үнэмшилтэй зогсоор байх юм. Нийслэлийн есөн дүүрэг, 21 аймаг үерийн гамшигт өртөж, хэдэн тэрбумын хохирол амсчихаад байхад ч УИХ-ын гишүүдэд найр наадам л чухал байсан юм. Ядарсан ард түмнээ харин шанага, данх, орос гутлаар хуурчихаад л "улсын ажил унаагүй, улстөрчид бид чинь завгүй ажиллаж байна" гэсэн пиараа хийсээр л байлаа. Ард түмнээс үнэмлэхүй олонхийн эрх авч, 65 суудал авсан тэдний бүрэн эрхийн хугацаа талдаа орчихож. Гэвч амласан мөрийн хөтөлбөр нь хэрэгжсэнгүй. Сургууль, цэцэрлэг барина, намар гэхэд нэг ч хүүхэд цэцэрлэг, сургуульгүй үлдэхгүй гэсэн амлалт өгсөн ч нээлт ойртож, бүртгэл эхлэхтэй зэрэгцэн аанай л сугалаа, бүртгэл гэсэн арга ядсан зүйлсээр аргацааж эхлэв. 35 хүүхэд багтаах ёстой цэцэрлэгийн бага ангид гэхэд л 160 хүүхэд бүртгүүлж байна, улстөрчид өө. Энэ хэдхэн шалтгаан л УИХ-ын ээлжит бус чуулганыг хуралдуулах хангалттай том шалтгаан баймаар санагдана. Хаврын чуулган завсарласны дараахан нэр бүхий гишүүд ээлжит бус чуулган зарлах шаардлагыг УИХ-ын дарга М.Энхболдод хүргүүлж байлаа. Тэд төрийн албан тушаалыг хууль бусаар зарсан гэх 60 тэрбумын асуудлаар нээлттэй сонсгол хийх шаардлага хүргүүлж байсан удаатай. Гэвч Хуульзүйн байнгын хороо нь хуралд, Тагнуулын байгууллага нь мэдэгдэл хий гэх мэтээр аргацааж суусаар өнөөдрийг хүрлээ. Үнэхээр л 60 тэрбумын наймаа явсан уу, хэн ямар албан тушаалыг хэдэн төгрөгөөр худалдаж авсныг тодорхой болгохгүй бол улстөрчдийн попордог, оноо авдаг сэдэв болж хувирчээ. Үүнийг сэтгүүлчид ч бус сөрөг хүчний зүгээс ч удаа дараа мэдэгдсэн. Ерөнхийлөгч ч хэд хэдэн удаа УИХ-ын даргад албан тоот илгээлээ. Дээрх бичсэн хэд хэдэн ноцтой асуудлыг УИХ нэн яаралтай хэлэлцэж, ээлжит бус чуулган зарлах ёстой гэдгийг хэдхэн өдрийн өмнө АН-ын бүлгээс мэдэгдсэн удаатай. Гэвч сөрөг хүчнийхээ үгийг тэд нохой хуцаж буйн чинээ ч тоосонгүй. "Жингийн тэмээ явж л байдаг, жингэр нохой хуцаж л байдаг" гэгчээр төр чинь болохгүй байна, Гүйцэтгэх засаглалдаа хариуцлага тооц, чадахгүй бол УИХ-аа тарааж, шинээр бүтцээ зур хэмээн мянга түм мэдэгдэл гаргаж, хүний өөрийн улстөрчид нь албан тоот илгээгээд ч аядуу зөөлөн дарга "хэлэлцэх асуудал байхгүй" гэсэн шалтгаан тоочоод нам гүмхэн суучихлаа. Харин 32, 33-ын бүлгийн санаа чилээж буй ганц асуудал нь Хэнтийн нөхөн сонгуульд хэрхэн ялах вэ гэдэг асуудал. Тооны харьцаа нь тэнцэж, төр самрах шийдвэр гаргахад хэцүү болсон учраас нөхөн сонгуулийн суудлыг ямар ч хамаагүй үнээр авахаар улайрч байх юм. Нөгөөтэйгүүр, Тусгаар тогтнолын ордонд зам тээврийн салбарыг удирдах гэсэн ил далд марафон өрнөж, үерийн гамшиг, үхэл хагацал, үндэсний аюулгүй байдлаа ч үл тоон хэмлэлдэж буйг нуугаад яахав. Ийм УИХ-аас юу ч хүлээх хэрэггүй нь тодорхой. Хууль зөрчсөн сайддаа хариуцлага ярьж чадахгүй, хүн хөнөөх хүртлээ зөрчилдсөн төрөө цэвэрлэж чадахгүй л бол УИХ-аа тараахад ч буруудах зүйл алга. Намрын чуулганы нээлт хүлээхгүй нэн яаралтай чуулганаа хуралдуулах цөөхөн хэдхэн шалтгааныг энд дурдая.

1. Эрдэнэт үйлдвэрийг хууль бусаар барьцаанд тавьсан асуудлыг цэгцлэх. /Тус үйлдвэр Арбитрын шүүхэд ялагдаж үйлдвэрийн үл хөдлөх хөрөнгийг царцаах, эрх бүхий албан тушаалтныг хилээр гарахыг хориглоод байгаа/
2. 60 тэрбумын наймааг эцэслэх /Төрийн албан тушаалыг хууль бусаар арилжаалсан гэх хэргийг эцэслэхгүй бол МАН-ын нэр бүхий албан тушаалтнууд үүнийг бодит хэмээн мэдэгдсэн удаатай/
3. Хүний амь үрэгдсэн шалтгаан нөхцлийг тодруулах /Албан бус эх сурвалжийн хэлж буйгаар талийгаач олон ч ноцтой баримтуудад хяналт шалгалт хийж, зөрчилтэй байсан гэх яриа бий/
4. Зам тээврийн сайдын томилгоог хийх /Дархан, Эрдэнэтийн замд өдөр бүр хүний алтан амь үрэгдэж байна. Энэ салбарыг эзэнтэй болгох, хийх ёстой, хүлээгдэж буй олон ажлыг хийлгэх нь чухал/
5. Төмөр замын асуудлаар ярилцах /Хугацаа дууссан 1000 вагон, 16 вагоныг шинийг авах мөнгөөр засуулсан асуудал, мөн зам засварын вагон байсаар байхад дахин оруулж ирсэн зэрэг ноцтой асуудлыг хэлэлцэх, нээлттэй сонсгол явуулах/
6. Турк улсын иргэнийг хулгайлахыг завдсан /Энэ талаар Засгийн газрын нэг ч сайд мэдэгдэл хийгээгүй. Харин сөрөг хүчний зүгээс Засгийн газартай зөвшилцсөн гэх тайлбар өгч буй/
7. Засгийн газрын алдаа оноог хэлэлцэх, албан тушаалтнуудад хариуцлага ярих / Засаглалын хямралгүй, хариуцлагагүйн зудгүй төрийг бий болгоно хэмээсэн ч сахилга, хариуцлага бүх шатанд алдагдлаа/

...Энэ хэдэн шалтгаан ээлжит бус чуулган хуралдуулах зайлшгүй шаардлагатай гэдгийг батлан харуулна. Эрх баригчид үүнийг мэдэж буй ч мэдэн будилж, чихээ бөглөн суусаар байна. Тэд нүдээ таглаж, чихээ бөглөж болох ч маргааш ард түмэн ямар дүн тавьж, хэрхэн тэмцэхийг энд сануулах нь илүүц билээ.

БАРИМТ & ТАЙЛБАР

АТГ АВЛИГЫН ХЭРГИЙГ ИНГЭЖ ШАЛГАДАГ

С.БУДРАГЧАА
budragchaas@gmail.com

АТГ-т энэ оны эхний хагас жилд иргэдээс 552 гомдол, мэдээлэл иржээ. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий 552 хэргийн баримт, материалыг шалгуулахаар иргэд АТГ-т иргэд хандсан гэсэн үг. Харин иргэдээс ирүүлж буй тэрхүү үнэ цэнэтэй материалыг АТГ хэрхэн шалгаж, шийдвэрлэж байгаа нь маш тодорхойгүй үлддэг. Иймд манай сонины энэ оны эхний хагас жилд цуврал нийтлэгдсэн Нийслэлийн архивын газрын дарга С.Гаваагийн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдлийг илчилсэн гурван цуврал нийтлэлд дурдагдсан бариммыг АТГ-ын комиссар, АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Э.Мөнхцэнгэл хэрхэн шалгаж, шийдвэрлэснийг та бүхэнд хүргэж байна.

Сонинд нийтлэгдсэн баримт:

... С.Гаваа нь зөвхөн 2013 онд л гэхэд “Архивын хөгжлийн сан” ТББ-ынхаа “Худалдаа хөгжлийн банк” дахь 452***899 дугаартай дансанд төрийн болон хувийн байгууллага, аж ахуйн нэгж, тэр бүү хэл өөрийнхөө удирддаг Нийслэлийн архивын газар зэрэг байгууллагаас 52 удаагийн гүйлгээгээр нийт 41.552.900 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байдаг. “Архивын хөгжлийн сан” ТББ-ын дансанд татан төвлөрүүлсэн мөнгөнөөсөө С.Гаваа АНУ-д суралцдаг ганц охин Б.Бадмааараг руугаа хоёр удаагийн гүйлгээгээр 4.250.000 төгрөг, өөрийн хувийн эзэмшлийн орон сууцныхаа төлбөрт 5.800.000 төгрөг шилжүүлсэн байв. Мөн 11.1 сая төгрөгийг бэлнээр, 7.4 сая төгрөгийг чек хэлбэрээр гаргуулж авсан тэдийгүй, өөрийн хувийн эзэмшлийн “У*У 55-56” улсын дугаартай автомашины гражийн төлбөр болох нэг сая төгрөгийг мөн л дээрх байгууллагаасаа шилжүүлсэн байна...

(Архивын хөгжлийн сан ТББ-ын Худалдаа хөгжлийн банкин дахь дансны хуулгыг хавсарган нийтэлсэн)

АТГ энэ баримтыг шалгасан байдал:

... 2012-2017 оны Аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн шалгалтын дүгнэлтээр Нийслэлийн архивын газрын санхүүгийн баримтанд зөрчил илрээгүй. Мөн Нийслэл архивын газартай хамтран хийсэн тодорхой ажил арга хэмжээ байхгүй байна...

Сонинд нийтлэгдсэн баримт:

... С.Гаваа 2016 онд А/35 тоот тушаал гарган УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн саналын хуудас, нэрсийн жагсаалт, бусад удирдлагын баримт бичгийг Сонгинохайрхан дүүргийн “Орбит комплекс”-ийн СӨХ-ны подвальд хадгалсан байдаг. Тэрхүү “Орбит комплекс”-ийн байрны СӨХ-ны даргаар С.Гаваагийн хадам ээж ажилладаг аж. Нийслэлийн архивын газрын дарга С.Гаваа архивын дээрх баримтуудыг хадгалалтын горим, технологийн шаардлага хангахгүй “Орбит комплекс”-ийн байрны СӨХ-ны подвальд нэг сарын 2,500,000 төгрөгөөр түрээслэх гэрээг байгуулсан бөгөөд зургаан сарын хугацаанд 15,000,000 төгрөг төлсөн байдаг аж ...

АТГ энэ баримтыг шалгасан байдал:

...Хадам ээжийнхээ СӨХ-д архивын баримт хадгалсан гэх асуудлыг шалгахад “Орбит комплекс” ХХК-тай өрөө түрээслэх гэрээ байгуулан архивын баримтыг хадгалж байсан байна. Архивын газраас гаргуулан авсан баримтаас харахад архивын баримт хадгалах байр олдохгүй, өөрийн гэсэн байр байхгүй болох нь тогтоогдож байна.

Сонинд нийтлэгдсэн баримт:

... НХААГ 2015 оны дөрөвдүгээр сард Нийслэлийн архивын газрын захиалгаар “Төрийн архивын цахим нөхөн бүрдүүлэлтэд тоон гарын үсэг нэвтрүүлэх онлайн систем болон дагалдах программ хангамжийг нийлүүлэх ажил”-ын тендерийг зарлан явуулж “Нью Соник” ХХК-г сонгон шалгаруулж байжээ. Тус компани уг программ хангамжийг 208,020,090 төгрөгийн өртөгтэйгээр зургаан сарын турш гүйцэтгэж, Нийслэлийн архивын газарт 2015 оны аравдугаар сард хүлээлгэн өгсөн байдаг. Уг программ хангамжид нэвтрэх админ эрхийг С.Гаваа нийслэлийн харьяа байгууллагуудад 120 мянган төгрөгөөр зарж, орлогыг уг программ хангамжийг хийхэд огт оролцоогүй “И Эл Эн” ХХК-ийн данс руу татсан байна...

(Тэндэрийн сонгон шалгаруулалт, мөнгө шилжүүлсэн баримтыг сонинд хавсарган нийтэлж байсан)

АТГ энэ баримтыг шалгасан байдал:

Нийслэлийн архивын газраас “цахим архив”-ын программ зохиолгохоор программын компаниудад хүсэлт хүргүүлж үнийн санал авсан байна. Тус компаниудаас “И Эл Эн” ХХК шалгарч “цахим архив” нэртэй программыг зохиож Нийслэлийн архивын газарт хүлээлгэн өгсөн байна. Иймд Засаг даргын харьяа нэгж байгууллагууд программын төлбөрийг тус компанийн данс руу хийдэг байж...

Иймд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.14 дүгээр зүйлийн 2.4 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Хэрэг бүртгэлтийн 180200225 дугаартай хэргийг хаасугай гэжээ.



НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
ПРОКУРОРЫН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 23 өдөр Дугаар 224 Улаанбаатар хот

Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай

Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих нэгдүгээр хэлтсийн хяналтын прокурор У.Солонго би, 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэргэ нээсэн, 170200225 дугаартай хэрэгт Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Э.Мөнхцэнгэл мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдөр хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай санал гаргаж прокурорын хяналтанд ирүүлснийг 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч хянаад ОЛСОН нь:

Нийслэлийн архивын газрын дарга С.Гаваа нь 2014 оны 05 дугаар сарын 14-18-ны өдрүүдийн хооронд Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Архив албан хэрэг хөтлөлтийн сургалтанд хамрагдсан хүмүүсээс 310 ам.доллар хураан авч завшсан гэх хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгахад сургалтанд Нийслэл дүүргүүдийн иргэдийн хурлын ажлын албаны дарга нар, дүүргүүдийн архив бичиг хэргийн ажилтнууд хамрагдсан байна.

Сургалтанд хамрагдсан хүмүүсийг тухайн үед Нийслэлийн архивын газарт төлөвлөлт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Рэгзэдмаа ахлах авч явсан бөгөөд зардлыг тухайн ажилчдын байгууллагаас нь гаргажээ. Сургалтанд хамрагдсан ажилчид нь өөрсдийн хүсэлтээр 310 ам.долларыг цуглуулж Бангкок хотод байх хугацаандаа байр, хоол, тээврийн зардал, бөлөг дүргэлэн зүйлд зарцуулсан болох нь Ц.Рэгзэдмаа, О.Бат-Ирээдүй, Г.Ононгуа нарын гэрчээр егсөн мэдүүлэг, сургалтын тайлан зэрэг баримтуудаар тогтоогдож байна.

Нийслэлийн архивын газрын дарга нь өөрийн үүсгэн байгуулсан “Архивын хөгжлийн сан” ТББ-аар ажил гүйцэтгэж мөнгө завшсан гэх асуудлыг шалгахад 2012-2017 оны Аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн шалгалтын дүгнэлтээр Нийслэлийн архивын газрын санхүүгийн баримтанд зөрчил илрээгүй, мөн Нийслэлийн архивын газартай хамтран хийсэн тодорхой ажил арга хэмжээ байхгүй байна.



1. Хэрэг бүртгэлтийн 180200225 дугаартай хэргийг хаасугай
2. Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан болон битүүмжлэгдсэн эд хөрөнгө үгүй болно.
3. Энэ тухай гомдол гаргагч мэдэгдсүгэй.
4. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Улсын Ерөнхий прокурорын газарт гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ХЯНАЛТЫН ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН АХЛАХ ЗӨВЛӨХ У.СОЛОНГО

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Д.БАЯРМАГНАЙ

МУБИС-Д БАГШ ШАЛГАРУУЛЖ АВНА

Багшийн сургуульд:
- Хөгжмийн онол, дуурьсахуйн ухаан, найрал хөгжим, MIDI хөгжмийн найруулгын багш, хөгжмийн зохиомжийн багш – 1
- Төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим, концертмейтр багш – 1
- Морин хуур, лимбэ, ерөнхий төгөлдөр хуурын багш – 1
- Бага боловсролын сурган, сэтгэл судлалын багш – 1

Боловсрол судлалын сургуульд:
- Тусгай хэрэгцээт боловсролын багш – 1
- Боловсрол судлалын багш – 1

Сургуулийн өмнөх боловсролын сургуульд:
- Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын багш – 1

ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Монгол улсын төрийн болон гадаадын их дээд сургуулиудыг магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудад багшилж байсан туршлагатай, судалгааны арга зүй эзэмшсэн, гадаад хэл (англи, орос, болон бусад), сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын зохих мэдлэгтэй, мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний чадвар эзэмшсэн, багаар ажиллах чадвартай, оюутнуудтай харилцах эв дүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролын шинэчлэлд нээлттэй, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн ёс зүйг сахидаг байх.

Бүртгэл: 2018 оны 08 дугаар сарын 16-17, 20-22 –ны өдрүүдэд /Ажлын цагаар/ МУБИС-ийн 1-р байрны /хуучнаар А байрны/ 108 тоотод явагдана.

Бүрдүүлэх материал:
- CV монгол хэлээр
- Бакалавр, магистр докторын дипломын баталгаажуулсан хуулбар
- Төрийн албан хаагчийн анкет
- Ажил байдлын тодорхойлолт
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Цээж зураг 3 хувь /3*4/
- Нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтэрийн хуулбар
- Шалгалтын хураамж 20.000 төгрөг /Хаан банк 5031749242/ төлсөн баримт

Шалгалт: 2018 оны 08 дугаар сарын 23-29-ний өдрүүдэд дараах чиглэлээр явагдана.
Үүнд:
1 Эхний ярилцлага
2 Мэргэжлийн шалгалт
3 Гадаад хэл /Англи болон орос хэл/-ний шалгалт
4 Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний чадварын шалгалт
5 Боловсрол судлалын орчин үеийн асуудлуудын шалгалт
6 Нэгдсэн ярилцлага

Жич: Тухайн шалгалтандаа тэнцээгүй ажил горилогчийг дараагийн шатны шалгалтад оролцуулахгүй бөгөөд хураамжийг буцаан олгох боломжгүй болохыг анхаарна уу.
Дэлгэрэнгүй мэдээллийг www.mnue.mn/ хаягаас харна уу.

Холбогдох утас: 311547, 99957309
Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба

МЭДЭЭЛЭЛ

Барьцаагүй зээл олгоно хэмээн иргэдийг залилжээ

Б.ӨНӨРТОГТОХ

Сүүлийн үед нийгмийн сүлжээгээр хуурамч хаяг ашиглан иргэд, байгууллагыг залилан мэхлэх хэрэг нэг бус удаа гарсан талаар Санхүүгийн зохицуулах хорооноос мэдэгдлээ. Гэмт этгээдүүд залилан мэхлэх үйлдэлдээ нэр бүхий ББСБ зэрэг Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалт бүхий, албан ёсны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн нэрийг барьж байгаа нь давхар хохирол, ихээхэн хор уршиг дагуулж байгаа юм. Залилан мэхлэх үйлдлээ гэмт этгээдүүд иргэдийн итгэмтгий, мэдээлэлгүй байдалд тулгуурлаж, “барьцаагүй зээл олгоно” гэх мэтээр хууран, цөөнгүй хохирогчийн багагүй хэмжээний мөнгийг зээлийн шимтгэлийн урьдчилгаа зэрэг нэрээр дансаар шилжүүлэн авч байжээ. Энэ мэт үйлдлийг иргэдийн гомдол, мэдээлэлд үндэслэн хууль хяналтын болон холбогдох эрх бүхий байгууллагууд шалгаж байгаа аж. Иймд зээл авах зэрэг санхүүгийн үйлчилгээг ББСБ болон бусад санхүүгийн байгууллагаас авахдаа тусгай зөвшөөрөл, холбогдох баримтыг сайтар нягталж байх шаардлагатайг сануулав. Мөн зээлийн шимтгэл, урьдчилгаа болон бусад шаардлагатай мөнгөн хөрөнгийг үл таних этгээдийн дансанд магадлалгүй, баримтгүй шилжүүлэхгүй байх, хуурамч мэдээлэлд хууртан эд хөрөнгөөрөө хохирохгүй байхыг иргэд, олон нийтэд сэрэмжлүүллээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018.08.21.
XIII.1.1.5.2 Шинээр баригдах сургуулийн барилгын цахилгаан хангамжийн 2*250ква, 10/04кв-ын дэд өртөөний ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 12 дугаар хороо/
Тендер шалгаруулалтын дугаар: БСШУСЯ/201807449

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх бүхий тендерт оролцогчдоос Монгол улсын 2018 оны төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх XIII.1.1.5.2 Шинээр баригдах сургуулийн барилгын цахилгаан хангамжийн 2*250ква, 10/04кв-ын дэд өртөөний ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 12 дугаар хороо/ ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын талаар дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь тендерийн төсөвт өртгөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017 онуудын аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний үнийн дүн нь тендерийн үнийн дүнгээс багагүй байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

- 03.2.3 заалтын дагуу.
- 03.2.3. 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ.
- 03.2.4. 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ.
- 03.6 туршилт тохируулгын ажил үйлчилгээ.

Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гэрээгээр гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу шаардагдах тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт 2,300,000.00 (Хоёр сая гурван зуун мянган) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 20 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулдаг цахим худалдан авах ажиллагааны төлбөргүй сургалтад хамрагдахыг зөвлөж байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтад заасан “Тендер оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно.”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Засгийн газрын III байр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, 1 дүгээр давхар 109 / б тоот. Санхүү, хөрөнгө оруулалтын газар.
Утас: 976-11-260729 Цахим хаяг: www.tender.gov.mn

ЯРИЛЦАХ ТАНХИМ

С.ЭРДЭНЭ: Ийм том зовлогыг даах араг яс МАН-д байгаа болов уу гэж намынхандаа хэлж байсан

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

-Хотын дарга асан Э.Бат-Үүл нөхөн сонгуульд нэр дэвшинэ гэдгээ албан ёсоор зарласан байсан. Ардчилсан намыг нэр дэвшигчээ тодруулсан юм байх гэж ойлгосон?

-Тэрийг би мэдэхгүй. Э.Бат-Үүл ямар шугамаар нэр дэвшинэ гэдгээ зарласныг мэдэхгүй юм. Манай намаас Э.Бат-Үүл ч юм уу, өөр хэн нэгнийг дэвшүүлэх асуудал одоогоор яриагүй.

-Э.Бат-Үүл АН-даа байгаа юу, эсвэл гарсан юм уу?

-Э.Бат-Үүл намаас гарлаа гэж өргөдөл өгөөгүй. Тэгэхээр АН-даа байгаа байлгүй дээ.

-Нөхөн сонгуулийг шударга явуулахад хэрхэн хяналт тавьж ажиллах вэ. Сонгууль бүрийн дараа царцааны нүүдэл яригддаг шүү дээ?

-Хуулиараа шилжилт хөдөлгөөнийг зогсоох ёстой. Нэг тойрогт бид асар өндөр хяналт тавих боломжтой юм. Мэдээж нийслэлийн Баянзүрх дүүргээс 100 хүн очоод тэнд санал өгөөд байвал онигоо болно шүү дээ. Гэхдээ энэ бүхэн ил тод харагдана. Хэнтий аймгийн 42 дугаар тойргийн иргэд эрхээ эдлээд саналаа өгөх ёстой юм. Олны хэлдгээр царцаа нүүлгэж самрахгүй байлгүй. Хэрвээ ийм байдал үүсвэл гэм буруутай этгээд нь хариуцлага хүлээх байх.

Өөрсдийнхөө томилсон албан тушаалтанд хариуцлага тооцож чадахгүй бол тарах хэрэгтэй

-Ээлжит бус чуулган хуралдах уу, үгүй юу гэдэгт хүлээлт үүсээд байна. Яаралтай шийдэх хэд хэдэн асуудал байна шүү дээ. Тухайлбал, Үндсэн хууль, улс төрийн намуудын тухай хууль, Зам тээвэр хөгжлийн сайдын асуудал гэх мэтээр хэлэлцэх асуудал цөөнгүй байна?

-Ээлжит бус чуулган хуралдах шаардлага байна уу гэвэл байна. Дан ганц дээр дурдсан үндэслэлүүдээс гадна өчнөөн зүйл байна. Өнөөдөр нийгэм эдийн засгийн байдал хүндхэн байгаа. Намрын бэлтгэл ажлууд салан задгай байна шүү дээ. Гол үүрэг хүлээж буй яам эзэнгүй болчихлоо гэх мэтээр хэлээд байвал олон зүйл бий. Эрх баригч намын хувьд эдийн засаг өсч байна, ард түмний амьдрал сайжирч байна гэж хэлдэг. Харин бид үүнд эсрэг байр суурьтай байгаа юм. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өдөр тутамд өсч байна. Шатахууны үнэ хэд дахин нэмэгдлээ. Цалин тэтгэвэр, иргэдийн бодит орлого нэмэгдсэнгүй. Төсвийн орлого нэмэгдэж, бусад эх үүсвэрээс орж ирж байгаа мөнгөн урсгал нэмэгдээд байгаа атлаа улс орон даяар бүтээн байгуулалтын ажил огт явахгүй байна. Нэг айлын орон сууц, нэг км зам ч тавьсангүй. Дандаа л өмнөх жилүүдэд дутуу хийсэн ажлуудыг хагас, хугас хийснээ их зүйл бүтээсэн мэтээр олон нийтэд ойлгуулж байна.

-Ээлжит бус чуулган зарлахгүй байгаагийн цаад шалтгаан юу юм бэ?

-Зарлахгүй байх шалтгааныг би харахгүй байгаа юм. Магадгүй УИХ-ын гишүүдийн ирц хангалтгүй зэрэг янз бүрийн шалтгаан хэлж болно. Миний ойлголтоор МАН-ын дотоод зөрчил олон нийтэд ил болохоос болгоомжлоод, аль болох намрын чуулганыг хугацаанд нь эхлүүлэхээр төлөвлөж байгаа байх. Тэр болтол дотоод зөрчлөө далдлах нуух, болж өгвөл жоохон зохицуулалт хийхээр оролдож байгаа болов уу гэж харж байна. Ээлжит бус чуулган хуралдах шаардлага бий. Ээлжит бус чуулганаар шийдэх олон асуудал байгаа. Манай намын хувьд ээлжит бус чуулган хуралдуулахад бэлэн. Бид дэмжсэн байр суурьтай байгаа.

-Олон нийтэд хүргэх мэдээлэл нь арай өөр байгаа шүү дээ?

Тийм ээ. Өр барагдуулсан гэж их шоу хийж байна. Үнэндээ бол өр барагдуулаагүй. Монгол Улсын гадаад өр 27.5 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээнд байна. Нэг ам.долларын ч өр хасагдаагүй. Олон түмэнд ойлгуулахдаа У.Хүрэлсүхийн Засгийн газар, Ч.Хүрэлбаатар гэдэг Сангийн сайд хоёр мундаг ажиллаж байгаа мэтээр ярьж байгаа юм. Гэтэл яг үнэндээ Монгол Улсын гадаад өр тэр дундаа Засгийн газрын өөрийнх нь өр өссөн үү, гэхээс буураагүй. Өнгөрсөн хоёр жил гаруйн хугацаанд гадаад өр гурван тэрбум гаруй төгрөгөөр өссөн. Бид намраас эхлээд шаардлагуудаа тавина.

-Шаардлага тавьсан ч үр дүн муутай байна шүү дээ?

-Бид ямар үндэслэлээр өр өсөөд байгаа юм бэ. Ямар бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийсэн болоод гадаад өр өсөв. Их мөнгөний урсгал хаашаа орж, юунд зарцуулагдаад байна вэ гэдгийг асууна. Хэрэггүй агентлаг, газруудын орон тоог нэмээд байдаг. Үнэндээ бол бодит амьдралд иргэдэд очиж байгаа үр өгөөж алга. Цаашид ийм байдлаар яваад байх юм уу. Сайд нарын багцын дүн өсч, тансаглал хэрээс хэтэрч байгаа. Тансаг зэрэглэлийн машиныг талх шиг худалдан авдаг болсон. Тансаг зэрэглэлийн машиныг голлон худалдан авч байгаа хүмүүс төрийн албаныхан байгаа юм. Яасан ч их мөнгөтэй юм, ямар ч тансаг юм. Хувийнхаа мөнгөөр авч байгаа бол юм хэлэх эрх байхгүй. Төрийн мөнгөөр ингэж тансаглаж байгаад үнэхээр харамсч байна. Ямар ч хяналт алга. Өрийг өрөөр дардаг. Ийм байдлаар олон нийтийн тархи толгойг угааж байгаа. Бүрэн эрх дуусахад жил гаруйхан хугацаа үлдлээ. Нөгөө л албан тушаал, сандал ширээгээ булаацалдсан хэвээр. Энэ бүхнийг хараад миний анхны өгсөн үнэлэлт дүгнэлт өдөр ирэх бүр улам баталгаажиж байна. Анх үнэмлэхүй олон суудлыг сонгогч нарт МАН-д өгсөнийг гайхаж байсан. Нөгөө луйвар нь явчихсан уу гэж хардаж байсан. Тэр үед ийм том зовлогыг даах араг яс МАН-д байгаа болов уу гэж намынхандаа хэлж байлаа. Гэтэл өнөөдөр олны итгэлийг тэд дааж чадсангүй. Дотроо хэд хэд хуваагдсан. Бүх аймагт нам нь хуваагдсан. Тэд үнэхээр засаглаж чадахгүйгээ харууллаа.

> ...Албан тушаалын томилгоо бол гурав, дөрөвдүгээр асуудал. Улс орны хувь заяа, эрх ашиг, ард түмний амьжиргаа уг нь нэг номерын асуудал шүү дээ. Чухал асуудлаа сүүлд нь тавьчихаад эрх мэдэл, албан тушаалаа нэн тэргүүнд тавьж хэрэлдээд суугаа нь туйлын харамсалтай. Өнөөдөр хариуцлага алдсан албан тушаалтныг дэвшүүлж байна. Миний хувьд "УБТЗ"-ынхан бүрэн бүрэлдэхүүнээрээ хариуцлага хүлээх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Гэтэл энд ажиллаж байсан нөхдүүдээс дэд сайдыг томилж байх жишээтэй. Энэ бол туйлын хариуцлагагүйн жишээ юм. МАН хариуцлага тооцож чаддаггүй гэдгээ харуулж байна...

-Таны зүгээс Засгийн газарт ямар үнэлэлт дүгнэлт өгч байна вэ. Тэр дундаа хариуцлагын асуудалд?

-2016 онд МАН ямар том мөрийн хөтөлбөр дэвшүүлж, сонгуульд оролцлоо. Маш том амлалт өгч ард иргэдийн итгэлийг авсан. Харамсалтай нь тэр амлалтаасаа нэгийг нь ч биелүүлсэнгүй. Амлалтынхаа эсрэг явлаа. Ардчилсан намын эхлүүлсэн, хийсэн сайн ажил бүхнийг зогсоосон. Муу гээд бүгдийг нь зогсоосон шүү дээ. Гэтэл түүрийг нь сайжруулаад явсан нь хаа байна. Түүнээс илүү сайн ажил эхлүүлсэн нь хаа байна вэ. Хэт их улстөржилт ямар аюултай байдаг вэ гэдгийн бодит жишээг харуулж байна. Овоодоо энийг хийсэндээ гээд хэлчих зүйл үнэхээр алга. У.Хүрэлсүхийн Засгийн газар анх ямар гоё лоозон дэвшүүлж гарч ирлээ. Хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албыг бий болгоно гэсэн. Юун хариуцлагатай ёс зүйтэй төрийн алба бэ. Төрийн албан хаагчид нь ажил дээрээ архидаж, нэгнийхээ аминд хүрлээ. Авлигаа цэгцэлнэ гэсэн. Юун авлига цэгцлэх вэ. Ганцхан жишээ дурдахад тендерүүд замбараагаа алдаж, татвар авч байгаа юм шиг арван хувийг авч байна гэсэн яриа хаа сайгүй. Ингээд хэлэхээр намайг гүтгэсэн гэх байх.

-Эрх баригч намын нөхцөл байдал энэ хэвээр үргэлжилбэл яах вэ?

-Улс орны өмнө амлалт өгчихөөд, үүрэг хариуцлага хүлээчихээд, түүнийгээ биелүүлж чадахгүй бол энэ УИХ оршин тогтнох шаардлагагүй. Өөрсдийнхөө томилсон албан тушаалтанд хариуцлага тооцож чадахгүй бол тарах хэрэгтэй.

-МАН-ынханд бялуу хуваах хэд, хэдэн албан тушаал гараад ирсэн. Зам тээвэр хөгжлийн сайдаас эхлээд "УБТЗ"-ын даргыг шинээр томилох шаардлага байгаа?

-Албан тушаалын томилгоо бол гурав, дөрөвдүгээр асуудал. Улс орны хувь заяа, эрх ашиг, ард түмний амьжиргаа уг нь нэг номерын асуудал шүү дээ. Чухал асуудлаа сүүлд нь тавьчихаад эрх мэдэл, албан тушаалаа нэн тэргүүнд тавьж хэрэлдээд суугаа нь туйлын харамсалтай. Өнөөдөр хариуцлага алдсан албан тушаалтныг дэвшүүлж байна. Миний хувьд "УБТЗ"-ынхан бүрэн бүрэлдэхүүнээрээ хариуцлага хүлээх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Гэтэл энд ажиллаж байсан нөхдүүдээс дэд сайдыг томилж байх жишээтэй. Энэ бол туйлын хариуцлагагүйн жишээ юм. МАН хариуцлага тооцож чаддаггүй гэдгээ харуулж байна.

ӨДРИЙН ТОДРУУЛГА

С.ЧИНЗОРИГ: ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭГ 320 МЯНГАН ТӨГРӨГ БОЛГОЖ ШИНЭЧИЛЛЭЭ

Б.ПҮРЭВЖАВ
b.puujii11@gmail.com

Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороогоор Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320 мянган төгрөг болгосон шийдвэрийг өчигдөр танилцуулсан юм. Энэ талаар ХНХ-ын сайд С.Чинзориг, МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар мэдээлэл хийлээ. Энэ талаар ХНХ-ын сайд С.Чинзоригоос цөөн асуултад хариулт авсан юм.

-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны нэгдүгээр сарын 01-нээс эхлэн нэмэхээр болжээ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуулийн дагуу хоёр жилд тутамд 01-ээс доошгүй удаа шинэчлэх ёстой. Энэ дагуу Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо хуралдаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг цагийн 1904, өдрийн 15200, сарын 320.000 төгрөг болгож шинэчлэн баталлаа. Энэ шийдвэрийг 2019 оны нэгдүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөнө. Мөн 2019 оны төсвийн төсөл боловсруулах ажил үргэлжилж байна. Тиймээс энэ төслийг боловсруулахаас өмнө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэх шаардлагатай учраас яаралтай мэдээлэл хийлээ.

-Төрийн албан хаагчдын цалинг дагаад нэмэх үү?

-Төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээ 380 мянган төгрөг байгаа. ОУВС-тай хийсэн гэрээ хэлэлцээрийн дагуу төрийн албан хаагчдын цалинг нэмэх эсэх асуудлыг энэ оны дөрөвдүгээр улиралд багтаан хэлэлцэх ёстой.

-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэхээр дагаад түүнтэй дүйцэхүйц торгууль нэмэгдэх үү. Энэ асуудалд ямар нэгэн хяналт тавьж байгаа юу?

-Торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй шууд уяагүй. Тодорхой нэгж тогтоогоод нэгжээр торгуулийн хэмжээг заадаг болсон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дагаад торгуулийн хэмжээ өсдөг нь буруу жишиг юм.

-Багш нар цалингаа нэмэгдүүлэхээр шаардаад байгаа шүү дээ. Үүнд хэрхэн анхаарч байгаа вэ. Ажил хаяхгүй байх талаар ямар арга хэмжээ авах вэ?

-Багш нарын түр хорооноос цалин нэмэхгүй бол ажил хаяна гэсэн мэдээлэл байгаа. Одоогоор манай яаманд албан ёсоор мэдэгдсэн юм алга. Монгол Улс өөрийн хууль тогтоомжтой. Хэн дуртай нь ажил хаяна гэж нийгмийг донсолгоод айдаст автуулж, дарамталж болохгүй. Ажил хаяна гэдэг бол Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдсан харилцаа. Түр хороо гэж байгууллага гарч ирээд улсын хэмжээнд ажил хаялт зохион байгуулчихдаг эрх зүйн үндэс байхгүй.

Цалин нэмэх шаардлага байгааг мэдэж байна. Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдаж байгааг санах хэрэгтэй. Ажил хаях асуудал байхгүй байх.

-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлж байгаа талаар ОУВС-тай зөвшилцсөн үү?

-Өнгөрсөн хоёрдугаар сард ОУВС-гийнхан ирж ажилласан. Энэ үеэр бид төрийн албан хаагчдын цалинг зайлшгүй нэмэх шаардлага байна гэсэн асуудлыг хөндсөн. 2014 оноос хойш төрийн албан хаагчдын цалинг огт нэмээгүй. Зайлшгүй нэмэх шаардлага байна гэсний үндсэн дээр энэ оны дөрөвдүгээр улиралд төрийн албан хаагчдын цалинг нэмэх эсэх асуудлыг хэлэлцэхээр болоод байна. Өнөөдөр үргэлжлүүлэн төрийн албан хаагчдын цалинг нэмэх эсэх асуудлаар хуралдана. Нэгдсэн ойлголтод хүрвэл төрийн албан хаагчдын цалинг нэмэх эсэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

> ...Зайлшгүй нэмэх шаардлага байна гэсний үндсэн дээр энэ оны дөрөвдүгээр улиралд төрийн албан хаагчдын цалинг нэмэх эсэх асуудлыг хэлэлцэхээр болоод байна...

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Сайд Н.Цэрэнбат Дорноговь аймагт ажиллалаа

Б.ӨНӨРТОГТОХ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг нар Дорноговь аймгийн Айраг, Сайншанд сумдад ажиллав. Энэ үеэр төмөр зам дагуух газруудад төмөр үерийн далан байгуулах, усжуулалт, ойжуулалт, хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар нутгийн удирдлагуудтай ярилцаж, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагаатай танилцаж, ажиллагсадтай уулзан, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэсэн юм. Тухайлбал, “Цайны зам” дагуух аялал жуулчлалын гол маршрут болох Улаанбаатараас Замын-Үүд хүртэлх авто замыг дагасан дэд бүтцийг бий болгох, говийн бүсийн аялал жуулчлалыг өргөжүүлэх, Дорноговь аймагт тасралтгүй ажиллах ажлын байр бий болгох талаар ярилцаж, тус бүс нутагт ойжуулалт хийхийн тулд ойн зохистой загвар бий болгох, арчлах талаар судлах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй уулзаж, тулгамдсан асуудлууд, тэдгээрийн гарц, шийдлийг хамтдаа ярилцлаа. Уулзалтын үеэр хяналтын техниктэй холбоотой шаардлагатай асуудлыг яаралтай шийдвэрлэхийг холбогдох газрын дарга нарт үүрэг болгов. Мөн Айраг суманд болсон байгалийн гамшигт үзэгдэл, үерт автсан айл өрхөд гэр гардуулах үйл ажиллагаанд оролцож, үерийн үеэр мэргэжлийн өндөр ур чадвар гарган, идэвх зүтгэлтэй ажилласан зарим хүнийг ЭМЯ-ны “Хүндэт тэмдэг”, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”,”Жуух бичиг”, АЗД-ын “Жуух бичиг”, “Өргөмжлөл”, мөнгөн шагналыг тус тус гардуулж өглөө.

У.Бямбасүрэн: Зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцно

Б.ӨНӨРТОГТОХ

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын албан даалгаврын биелэлтийг өнгөрөгч долоо хоногоос эхлэн шалгаж эхэлсэн билээ. Тодруулбал, ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатарын тушаалаар яам, агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газруудад ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэнгээр ахлуулсан шалгалтын ажлын хэсэг ажиллаж байгаа юм. Шалгалтаар хууль, тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан, авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдсон, хүнд суртал гаргасан, ажлын байранд архидан согтуурсан албан тушаалтантай хариуцлага тооцож, ажилласан эсэхийг дүгнэж, Засгийн газрын албан даалгаврыг хэрэгжүүлэх талаар яамдын гаргасан төлөвлөгөө түүний биелэлтийн явцыг хянах юм. ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн энэ талаар ярихдаа “Албан даалгаврын тайлангийн хэрэгжилтийг ирүүлж байгаа. Гэхдээ төрийн албан хаагчдын ёсзүй, цаг ашиглалтыг шалгаж үзэх нь зүйтэй гэж үзсэн учраас шалгалт явуулж байна. Яам, агентлагийн бүгдийг нь шалгана. Урьдчилсан байдлаар дүгнэхэд сахилга хариуцлага боломжийн хэмжээнд байна. Яам агентлагийн удирдлагууд маш тодорхой үүрэг хариуцлагыг ажилчиддаа өгсөн байна. Дөрвөн групп гараад ажиллаж байна” хэмээлээ. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага бол Засгийн газрын үндсэн хоёр зорилтын нэг гэдгийг Ерөнхий сайд ч удаа дараа мэдэгдэж байсан. Шалгалтын ажлын хэсэг энэ долоо хоногт дүгнэлтээ гаргаж Засгийн газрын хуралдаанд танилцуулах бөгөөд хариуцлага, зөрчил дутагдал гаргасан ажилтнуудад ч хариуцлага тооцоод явна гэв.

БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Монголд айлчилна

Б.ӨНӨРТОГТОХ

Монгол Улсын Гадаад Харилцааны Сайд Д.Цогтбаатарын урилгаар БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И энэ сарын 23-25-нд манай улсад айлчлах гэж байна. Гурван өдөр үргэлжлэх айлчлалынхаа үеэр БНХАУ-ын Гадаад хэргийн сайд тус улсын хөнгөлөлттэй зээлээр баригдах шинэ Төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын нээлтийн арга хэмжээнд оролцохоор төлөвлөжээ. Шинэ цэвэрлэх байгууламжийг Францын “Артилло” компаниар хийлгэсэн ТЭЗҮ-г үндэслэн, БНХАУ-ын засгийн газрын хөнгөлттэй зээлээр барих ажлыг гарын үсэг зурж эцэслэсэн. Улмаар 2020 он гэхэд цэвэрлэх байгууламж ашиглалтад орно хэмээн Барилга хот байгуулалтын яамнаас мэдээлж байгаа юм.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЦУЦЛАХ ТУХАЙ

Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

Нэг. Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан “төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг газар дээр нь шалгана” гэсэн заалтын хүрээнд шалгалт хийх явцад доорх аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн тусгай зөвшөөрлүүдийн тайланд тусгагдсан ажлууд газар дээрээ хийгдээгүй болох нь тогтоогдож Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 зүйлийн дагуу нотлох баримтыг бүрдүүлж ирүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн боловч заасан хугацаанд хүрэлцэн ирээгүй тул дараах ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг цуцалсугай.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-015481	2010.02.12	Хэнтий	Цэнхэрмандал	Мандал	ДНЦ ХХК
2	XV-019126	2015.10.21	Хэнтий	Хэрлэн	Адуун	Цэнгэг-Орог ХХК

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

Books "Ном" буланд тавтай морил

Ñ¯Í ÓËÑÛÍ Õ¯ÉÒÝÍ ÓÓËÛÍ ÁÈ×ÈÃ

Түрүүч нь №137 (4987)
Үргэлжлэл.

Үүр зассандаа эрдэж тэнгэрийн тогтоосон ёсыг гажуудуулж. Яахин ийм хүнийг бид хүн санах бэрх."хэмээгээд Зоу Юань, Зоурун нарыг дуудаж: "Энэ мал адгуус лугаа эр эмээ үзэлцэж, өстсөнөөн олж авсугай."хэмээгээд бага сэлэм аваад ирэхэд Сүнь Ли түр хориглон өгүүлрүүн: "Гү Дасао охин дүү чи баахан байзна. Миний нэг үгийг сонсогтун."хэмээсэнд Зоурун, Зоу Юань нар Гү Дасаог барьж авав. Үүнд Сүнь Ли ийн өгүүлрүүн: "Эрхэм мэргэн дүү Гү Дасао чиний хэлэх зөв боловч энэ хэргийг яаран хийж болохгүй. Аажим зай завсрыг олохоос бус учиргүй гянданыг эвдэж яахин болмуй. Та нар нэгэнт ийнхүү санаа тогтсон болбоос, би арга буюу мөн та нарыг дагахаас өөргүй. Гагцхүү аажим зөвлөе."хэмээсэнд Гү Дасаогийн уур намарч "Ийм бөгөөс үнэхээр журамтай"хэмээн өгүүлэв. Тэндээс Сүнь Лигийн эм Лоу Дасао маш айж, зүрх уушиг нь амаар гарах шахав. Үүнд цөм эвтэй болж, эдүгээ Се Жэнь, Зебао хоёрыг яахин авахыг зөвлөсөнд Сүнь Ли өгүүлрүүн: "Зоу Юань Дэн Юньшань уландаа довтлон очиж зардас ба буй бүхий юмаа авч түргэн эргэж ирэгтүн. Сүнь Синь дүү Дэнжоугийн хэрэмд Гү Дасаотай хоёул заншлан явж гянданд орж: Се Жэнь, Зебао хоёртой учрагтун. Түүний гадна Юэ Хэ даргад: Тэр өдрийн шөнө тэр цагт ирмүй."хэмээх үгийг захигтун. Түүний гадна өөрийн гэр байшингаа зарж арилган, буй бүхүй юмаа эдүгээ тэргэнд ачиж Ляншаний зүг өөрийн итгэсэн зардасыг илгээгтүн. Эдүгээ би харьж мөн хэдэн сайн цэргийн ардыг авч, буй бүхүй юмаа төхөөрөн бэлдэж даруй зам хөөж явуулъя. Түүний хойно бүгдээр энд нийлж Се Жэнь, Зебао хоёрыг булаан аваад бид хотын хэрмээс гарсугай."хэмээн зөвлөв.

Тэндээс Сүнь Синь эм Гү Дасаогийн хамт нэг нууц сэлэм авч гяндын зүг ирэв. Түүний хойноос Сүнь Ли, Сүнь Синь, Зоу Юань, Зоурун нарын дөрвөн хүн Лоу Дасао нарыг дагуулан бүгд зуу илүү хүн ирж, гянданы дэргэд чих тавин чагнав. Тэндээс гяндхны бага дарга Юэ Хэ хэдүйнээ Суньсинийн Гү Дасаог ирэхийг мэдсэн боловч зориудаар өгүүлрүүн:"Чи юун хүн, эдүгээ гянданд орох юу хэрэг? "хэмээсэнд Гү Дасао:"Би гянданы дотор будаа түгээх хэмээн ирэв."хэмээсэнд Юэ Хэ үл мэдэгчнээр дотогш оруулав. Тэр цагт гянданы их дарга Баози гянданы ялтныг байцаан үзэж явах лугаа тохиолдсонд Баози өгүүлрүүн: "Энэ ямар газрын эм хүн болоод гянданд орж ирэх ёс хаанав. Хуучин үгэнд гянданд эм хүн орох байтугай эр хүн ч үл орох барам, салхийг чивэл оруулж болохгүй хэмээсэн атал үүнийг яахин оруулав?"хэмээсэнд Юэ Хэ бага дарга өгүүлрүүн: "Энэ нь Се Жэнь, Зебао хоёрын төрсөн эгч. Эдүгээ тэр хоёр лугаа биеэр учирч будаа өгөх гэнэм."хэмээсэнд: "Түүнийг бүү оруулагтун. Чи будаа аваачиж өгөгтүн."хэмээн Юэ Хэгээр Се Жэнь, Зебаод өгүүлсэнд тэр Юэ Хэ "Мао Тайгүний тогооны шавхруу идэж цадсандаа бардан ам өгүүлэх мал чи"хэмээн урагш давшсанд Се Жэнь, Зебао хоёр гяндангийн нүхээр гарч, их дөнгийг барьж Баозийн толгойн тус цохиж газар унагасанд тархи нь урсаж нэгэнт үхэв.

Тэндээс гяндан дотроос Се Жэнь, Зебао хоёрыг аваад үүд гарсанд Сүнь Ли, Сүнь Синь хоёр олон зардас лугаа хамт баймуй. Үүнд Зоу Юань, Зоурун хоёр Мао Тайгүнгийн хүргэн Ван овогтыг барьж алаад, эднэр лугаа учирч эдүгээ Лян Шаньд урвах хэмээсэнд Се Жэнь, Зебао хоёр өгүүлрүүн: "Ах нар та сонс. Хэргийн үүсгэврийг үүдэж гаргасан Мао Тайгүний гэр хотлоорыг эс арилгаваас хожим бас энэ мэт хэрэг дэгдмүй. Эртний үгэнд "Үндэс нь эм болбоос үзүүр навч салаа ч эм. Үндэс нь хор болбоос үзүүр салаа навч ч хор хэмээжүхүй. Тиймийн тул эдний үндсийг эс ухаж авааас дахин ургамуй. Тиймийн тул өсөө авч явмуй." хэмээсэнд Сүнь Ли өгүүлрүүн: "Дүү нарын хэлэх зөв. Эдүгээ Лао Дасао, Гү Дасао хоёрыг тэрэг моринд унуулж, Сүнь Синь хэдэн цэргийн ард, зардастай Лян Шань Фуд очих замаар явж байгтун. Би Се Жэнь, Зебао, Зоу Юань, Зоурун нарын хамт очоод, Мао Тайгүн жаран насны баяр хийж, найр тавин цэнгэлдэн байх цаг тул тэдгээр Сүнь Ли нарын таван хүн шууд алалцан орж, Мао Тайгүний их багыг цөм хүй тэмтрэн алж дуусгаад алт мөнгөн эдлэл бараа, унах хэдэн сайн морь сонгон аваад явахыг хотын олон хүн мэдэж үзсэн боловч, хэн аймшигүй тэдний өмнөөс үг хэлмүй. Тус тус нүд балар, чих дүлий, нам гүм хаалгаа хааж суув. Үүнд Сүнь Ли нарын таван хүн гуч илүү газар явж эм хүүхэд, цэрэг зардас дээр ирээд удсангүй Ляншаний байгуулсан Ши Юнгийн архины пүүсэнд бүгдээр бууж цай архиууж Зоу Юань ийн өгүүлрүүн: "Эрхэм ахын өндөр алдар хэн гэдэг, архины пүүсний нэр юу?"хэмээсэнд Ши Юн өгүүлрүүн: "Би нь Ши Юн хэмээмүй. Архины пүүс нь Ляншаний харуул тавьсан газар."хэмээсэнд Зоу Юань өгүүлрүүн: "Тийм бөгөөс энэ Лян Шаньд Ян Линь, Дэн Фэй хэмээх хоёр жанжин буй юу?"хэмээсэнд Ши Юн өгүүлрүүн: "Бий. Эдүгээ Жу Зяжуан хэмээх гурван хотод байлдахаар Сүн Гүнминийг дагаж очоод буцаж ирээгүй. Сонсвоос Жу Зяжуаний Жубяогийг гурван хөвгүүний чадал нь маш их бөгөөд бас түүний багш Луань Тинюй хэмээгч нэгэн их рид төгссөн хүн тул эднэр лугаа эдүгээ хоёр удаа байлдаад ер дийлэхгүй гэнэм." хэмээсэнд Зоу Юань өгүүлрүүн: "Энэ Ян Линь, Дэн Фэй болбоос урьд над лугаа ах дүү болж явсан тул үнэхээр шударга журамтай. Энэ Жу Зяжуаний Луань Тинюй болбоос миний багш бөлгөө. Бид хоёрын сурсан эрдэм чадал ав адил бөгөөд бас ч багш шавь хэмээн танилцамуй. "хэмээсэнд Ши Юн маш баярлан ийн өгүүлрүүн: "Тийм бөгөөс эрхэм нөхрүүд өдий олноор хаашаа ямар учирт явааг асуусанд Сүнь Ли, Сүнь Синь хоёр өгүүлрүүн: "Бид Дэнжоугаас тухайлан албан хэргээр зарагдан ирээд эдүгээ санаа үл нийлмэгц тэд лугаа байлдаж, одоо Лян Шань ууланд урвах хэмээн ирэв."хэмээсэнд Ши Юн:"Тийм бөгөөс маш сайн.

Эдүгээ бид уулан дээр очиж хэл хүргэх."хэмээсэнд нэг цэргийн хүн ирж ийн өгүүлрүүн: "Жүнши Үү Шюэжү ирэв."хэмээсний дараа бас нэг цэргийн хүн ирж "Юань овгийн гурван жанжин ирэв."хэмээсэнд Ши Юн угтаж очоод цөмийг оруулж, бүгдээр архиууж, Жу Юань эдгээр учраа Үү Шюэжү нарт хэлсэнд Үү Шюэжү, Юань овгийн гурван ах дүү бүгдээр баярлалдан: "Тийм бөгөөс эдүгээ та нар уулнаа очих юу. Эднэрийн хамт Жу Зяжуанд очиж Сүн Гүнминд туслахаар очоод гавьяа бүтээж ирсэн хойно уулнаа очвоос сайн."хэмээсэнд тэдгээр цөм баярлалдан, тэндээс мордож Жу Зяжуаний зүг ирэв. Үүнд Үү Шюэжү даруй тэргүүлэн Жу Зяжуанд очиж Сүн Гүнминд учирваас Сүн Гүнмин хөмсгөө атируулан сууж буйг Үү Шюэжү үзээд даруй авчирсан архи махаа өгч, ийн өгүүлрүүн: "Эрхэм мэргэн ах сэтгэл зовох газаргүй. Тэнгэр дэлхий басхүү бидэнд туслахаар хэдэн баатар илгээв. Эдүгээ тэд нэр хойно Руань Сяо Эр , Руань Сяоци, Руань Сяо Үү нар лугаа хамт яваа. Эдүгээ эдний ирсэн учир Дэнжоугаас Жунжоуд алба хийхээр ирж, санаа үл нийлмэгц манай Лян Шаньд урвахаар ирээд, Шизунгийн архины пүүсэнд учраад, бидний Жу Зяжуанд байлдахыг сонсоод, урьд гавьяа бүтээж хожим журмын ах дүү болмуй."хэмээн бүгд зургаан сайн эрс ирэв." хэмээсэнд Сүн Жян маш баярлан есөн тэнгэр хэмээн давхар хишиг хайрласан мэт болж атируулсан хөмсгөө тавьж, архиа ууж сэтгэл нь тайтгарч байв. Үүнийг үл өгүүлмү.

Өгүүлэх нь, Үү Шюэжү эдгээр учрыг хэлсэнд Сүн Жян маш баярлан ийн өгүүлрүүн: "Тийм бөгөөс Үү Шюэжү чи даруй түргэн явж Лян Шаньд очиж дөрвөн сайн эрс авчрагтун."хэмээв. Үлгэрлэвээс, мөрөн далайд олон цэрэг далавч нэмж нисэх мэт болох. Уул хотын дээр байх цэргүүд хуучин дээл сольж шинэ хувцас өмсөх хэмээх лугаа адил болжухуй. Үүнд Үү Шюэжү Лян Шань ууланд буцаж ямар нэртэй хэн гэгч дөрвөн баатар эрсийг авчрахыг хойд бүлэгт үзэгтүн.

ДӨЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Үү Шюэжү давхар арга хэрэглэж эрхийг барих.
Сүн Гүнлин гурван удаа Жу Зяжуанийг байлдах.

Өгүүлэх нь: Тэндээс Үү Шюэжү Лян Шаньд хүн илгээж дөрвөн хүн авчруулахаар тогтсонд, үүнд чухам хэнийг явуулахар хэлэлцэн байтал Сүн Жян хувилгаан явдалт Дай Зүнг явуулах хэмээсэнд Дай Зүн даруй дагаж Лян Шаньд буцав. Чухам хэн нэртэй хүнийг авчрах хэмээвээс Пэй Сюань, Жинь Дажянь, Сяо Ран, Хоу Жянь болой.

Тэндээс тэдгээр Сүн Жян нар найрлан сууж байтал нэг цэргийн хүн ирж өгүүлрүүн: "Эдүгээ энэ баруун зүгээс үхэр хөтөлж, түүний дэргэд бас нэг архи дамнасан ба үхэрт архи ногоо ачсан төлөв бүхий хүн ирэхийг үзээд орж Сүн Жян д мэдүүлсэнд, Сүн Жян даруй угтаж уулын дээр байгуулсан цацарт авчирсанд тэр хүн өгүүлрүүн: "Өчүүхэн хүн нь энэ баруун хотод суух Ху Зяжуаний харьяат Хучэн хэмээх хүн бөлгөө. Өчүүхэн хүний хот урьд нэгэнт Жу Зяжуан, Ли Зяжуан хоёр хот лугаа маш найртай учир эртнээс эдүгээ хүртэл хавсран аж төрж бие биенээ үхэх амьдрахад туслах хэмээн харилцан маш зузаан нөхөрлөсөн дээр басхүү хотын гурван тэргүүлэгч тэнгэрт мөргөж хүж барьсан нь эдүгээ ах дүү бололцож, үр хүүхдээ эр эм болгох худгуй бололцов. Тиймийн тул эрхэм жанжин ноён та бүгд морилон ирж, Жу Зяжуан лугаа байлдсанд өчүүхэн хүний төрсөн дүү И Жан Чин хэмээх бага охин таны өмнөөс Жу Зяжуаний төлөөнөө эсэргүүцэн байлдаж өөрийн биеийг баригдах. Энэ нь Жу Зяжуаний Жубяогийн гуравдугаар хөвгүүнд богтолсон охин тул гуйх нь: И Жан Чинийг тавин илгээж өршөөх ажаамуу."хэмээн мөргөсөнд Сүн Жян тосож аваад дээш босгож ийн өгүүлрүүн:"Чи эдүгээ ийм учирт ирсэн болбоос дотогш орж, бид хэдэн үг хэлэлцсүгэй."хэмээсэнд тэр хүн даруй дотогш орж суув.

Тэндээс Сүн Жян өгүүлрүүн: "Чи эдүгээ ямар ажил хийж суудаг, чиний ураг төрөл хэн хичнээн хүн байдаг, басхүү чиний дүү И Жан Чин ямар эрдэм сурсан зэргийг нарийнаа асууж, ийн өгүүлрүүн: "Эдүгээ чиний дүү И Жан Чин манай сайн эрс лугаа байлдаж Ван Ихуг барьж аваачсан тул бид хариу бэлгээн авч, чиний дүүг барив. Чи хэрвээ дүүгээ авах хэмээвээс манай Ван Ихуг хүргэж ирвээс тавьж явуулахгүй бөгөөс бид хэрхэвч явуулахгүй."хэмээсэнд тэр Хучэн өгүүлрүүн: "Өчүүхэн хүний харьяат Ху Зяжуаний ноён тэр Ван И Ху хэмээгчийг Жу Зяжуанд хүргэж илгээв. "хэмээсэнд Сүн Жян өгүүлрүүн: "Түүнийг яахин Жу Зяжуанд хүргэв. Эдүгээ тэр хаана баймуй?"хэмээсэнд Хучэн өгүүлрүүн: "Эрхэм ноёны баатар Ван И Ху хэмээх хүний хүзүүнд гинж төмөр, гар хөлд төмөр гав тушаа торгож, гянданд хийв."хэмээсэнд Сүн Жян өгүүлрүүн:"Чи миний Ван И Хуг авч гарган ирж чадах болбоос би чиний охин дүүг даруй сольж өгье."хэмээсэнд Үү Шюэжү хажуугаас өгүүлрүүн: "Эрхэм түшмэл Хучэн чи сонс. Эдүгээ миний харьяат ноён Сүн овгийн тэргүүлэгч хэдүй чиний төрсөн дүү Ху Жан Чинийг чамд өгч Ван И Хуг сольж авах хэмээсэн нь дэмий хэрэг. Чи миний үгийг дагаваас би чамд нэг үг зааж өгье."хэмээсэнд Хучэн даруй "Сургахыг хүсмүй"хэмээн мөргөсөнд Үү Шюэжү ийн сурган өгүүлрүүн: Эдүгээ бид чиний дүү И Жан Чинг Лян Шань ууланд цэргээр харгалзуулан хүргэв. Тэр гэм олох газар үгүй. Манай уулын нэг өвгөн Сүн Тайгүн хэмээх хүнд тушааж сайнаар асруулан буй."хэмээгээд бас өгүүлрүүн:"Тиймийн тул чи эдүгээ Жу Зяжуан лугаа бидний эсэргүүцэх ба байлдаж алалцах цагт танай Ху Зяжуанаас бүү цэрэг хөдөлж, хүн илгээж хөдлөгтүн. Түүний гадна басхүү Жу Зяжуанаас хүн илгээж танай хотоос туслах цэрэг гуйваас тэр очсон хүнийг барьж даруй манай энд хүргэж ирэвээс би нь чамд тэр хүнийг илгээж, чиний төрсөн дүү И Жан Чинийг авчруулж та нарыг бас тусалмуй."хэмээсэнд Хучэн түшмэл тэдгээр авчирсан архи ногоогоо Сүн Жян нарт бэлэг болгон бариад Үү Шюэжүгийн хэлснийг цөм дагаж, Хучэн хотноо буцав.

Тэндээс Сүн Жян өгүүлрүүн: "Эдүгээ Дэнжоугийн Сүнь Ли, Сүнь Синь нарын мэдээ ойр ирэв."хэмээгээд очиж цөм угтан гарав. Үүнд Сүнь Ли өөрийн дарцгийг Дэнжоу хотоос тусгайлан байлдах их цэрэг хэмээн Лян Шань Фүгийн дарцаг сольж засав. Тэндээс Сүнь Ли нарын арав шахам сайн эрс зуу шахам цэрэгээ дагуулан Жу Зяжуаний хойд хаалган дээр шууд ирэв. Үүнд Жу Зяжуан хэрэмний хаалгыг цагдан байцаасан нэг цэрэг дотогш орж Луань Тинюй ба Жубяо нарын хэдэн жанжидад мэдүүлрүүн: "Эдүгээ их хэрэмний гадна нэгэн их цагаан хуяг дуулга өмссөн их жанжин цагаан дарцаг барьжухуй. Биений байдал нь найман чи өндөр, маш их баатар хүчтэй мэт хүн ирэв.Тэндээс тэр дарцагны дээр тавьж бичсэн үсэг нь "Дэнжоугийн их цэргийн жанжин Сүнь Ли" хэмээмүй."хэмээсэнд Луань Тинюй энэ үгийг сонсоод даруй Жубяод хэл хүргэв. Юу хэмээн үг хэлснийг түр өгүүлье.

Тэндээс Сүнь Ли өөрийн зоргоор худал зохион үг хэлэхийг дотроо хэдүйн бодож тогтоон, шууд хойд хаалгаар орох гэтэл их усны гүүр авсан тул орж болохгүй, усны захад хүлээн суув. Үүнд Луань Тинюй, Жубяод хэлсэн үг нь: "Манай хотын хойд хаалганы гадна "Дэнжоугаас ирсэн их цэргийн дарга Сунъли"хэмээн дарцаг барьж ирэв гэнэм. Үүнд Жубяо чи гурван хөвгүүн лугаа гар хөдөлж муу санаж үл болмуй. Энэ Сүнь Ли болбоос миний нэг сайн танил бөгөөд басхүү цэргийн эрдэм хамт сурч, нэг багшид багаас явсан тул би урьд очиж түүн лугаа учирч, ирсэн хэргийг аминчхан эрье."хэмээсэнд Жубяо даруй тэр үгийг дагаж Луань Тинюйгийн хариуг хүлээв. Тэндээс Луань Тинюй ёст малгай дээлээ өмсөж, хойд хаалганы хэрэм дээр гарч үзвээс үнэхээр Сүнь Ли дүү мөн тул даруй хаалгаа нээж дотогш оруулахаар усны гүүрийг тавьж гараас нь барьж мэндээ мэдээд, хоёр биеэ хүндлэн, бусад жанжин цэргүүд цөм дагаж оров. Үүнд Луань Тинюй гэртээ оруулж цай бариад, чухам ямар хэргээр ирсэн ба яахин ийм олон цэрэг дагуулан ирснийг нэг нэгнээр асуусанд Сүнь Ли өгүүлрүүн: "Өчүүхэн дүү Дэнжоу хотоос харьяат ноёны тушаал дагаж Юньжоу хотыг харгалзахаар хэдэн түмэн цэргийн жанжин болж ирээд байтал, харьяат ноёноос таны жанжин Жу Зяжуан хэмээх газрын хотыг Лян Шань Фүгийн урвасан хулгай Сүн Жян, Чаогай нар цэрэг жанжин мордуулж идэх хэмээн сонсоод, өчүүхэн намайг таныг туслуулахаар илгээв.Тиймийн тул өмнө хаалгаар ирэх гэтэл Ляншаний урвасан хулгай нар урд ууланд бугшижухуй. Үүнд хойд хаалгаар ирэв."хэмээсэнд Луань Тинюй маш баярлан, үлгэрлэвээс гандаж хатсан газар тэнгэрээс хур орж ногоо дэлгэрэх лугаа адил дотор нь маш тайтгарч, Жубяо хэмээх Жу Чюванг Жуху нарын гурван хөвгүүнийг уриулж ирүүлээд, их танхим дээр сууж бүгдээр ёс ёслон байв. Үүнд Луань Тинюй өгүүлрүүн: "Эдүгээ миний нэгэн төрлөөс өөргүй маш баатар дүү Сүнь Ли Дэнжоугийн цэрэг захирах их жанжин болж, эдүгээ манай гурван хүн хотыг хамгаалах ба Лян Шань уулын урвасан хулгай Сүн Жян нарыг хавсран барих хэмээн ирэв."хэмээсэнд Луань Тинюйгийн үгийг Жубяо сонсоод "Тэнгэрээс зарлиг бууж биднийг тусалсан нь үнэхээр их заяатай билээ. Гагцхүү эрэхэм дүү Сүнь Лигийн алдар нэр, овгийг эрт сонслоо. Эдүгээ энд гийгүүлэн ирсэн нь маш сайн."хэмээгээд

> "...Үү Шюэжү даруй тэргүүлэн Жу Зяжуанд очиж Сүн Гүнминд учирваас Сүн Гүнмин хөмсгөө атируулан сууж буйг Үү Шюэжү үзээд даруй авчирсан архи махаа өгч, ийн өгүүлрүүн: "Эрхэм мэргэн ах сэтгэл зовох газаргүй. Тэнгэр дэлхий басхүү бидэнд туслахаар хэдэн баатар илгээв. Эдүгээ тэд нэр хойно Руань Сяо Эр , Руань Сяоци, Руань Сяо Үү нар лугаа хамт яваа. Эдүгээ эдний ирсэн учир Дэнжоугаас Жунжоуд алба хийхээр ирж, санаа үл нийлмэгц манай Лян Шаньд урвахаар ирээд, Шизунгийн архины пүүсэнд учраад, бидний Жу Зяжуанд байлдахыг сонсоод, урьд гавьяа бүтээж хожим журмын ах дүү болмуй."хэмээн бүгд зургаан сайн эрс ирэв." хэмээсэнд Сүн Жян маш баярлан есөн тэнгэр хэмээн давхар хишиг хайрласан мэт болж атируулсан хөмсгөө тавьж, архиа ууж сэтгэл нь тайтгарч байв...

> "...Үндсийг олж бүрмөсөн хийвээс сайн. Үзүүрээр хийвээс хэрэг үл бүтмүй.Тиймийн тул та нараас нэг хүн барьсан нүүр олж, жич тэдий урьд барьсан манай хэдэн ах нар лугаа учирч, гяндангийн дотор энэ үгийг зөвлөлдөө, хэн учирваас сайн." хэмээсэнд Ян Сюнь, Сүн Жян д энэ үгийг хэлсэнд Сүн Жян тэр Сүнь Лигийн бодсон арга үнэхээр зөв.Үүнд Ши Сюг илгээж Сүнь Литэй хуурмаг байлдаж Сүнь Лид баригдаж, гянданд орж, өөр ах дүү Ван Вэйху, Ян Линь нар лугаа учирч, бүгдээр Сүнь Лигийн мэдээг хүлээж урваад, гяндналт гарч хот дотор байлдагтун."хэмээн сургаж, Ши Сюг гаргав...

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЦУЦЛАХ ТУХАЙ

Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

Нэг. Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг цуцалсугай.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-013677	2008.05.13	Улаанбаатар	Налайх	Зуун мод	Сайхандэлгэр Инвест ХХК
2	XV-017990	2015.04.22	Увс	Өлгий	Бодон уул	Юнайтед-Ойлшейл ХХК
3	XV-020310	2016.04.22	Дорнод	Гурванзагал	Салаа	Баянсүмбэр Богд ХХК
4	XV-019618	2016.04.22	Төв	Баянцагаан	Ухаа	Ээлтэй мод ХХК
5	XV-018627	2016.04.22	Завхан	Завханмандал, Ургамал	Мандал	Топдаймонд дриллинг ХХК
6	XV-017964	2015.04.22	Ховд	Алтай	Алтан гадас	ТИС андууд ХХК
7	XV-014873	2009.04.23	Дорнод, Сүхбаатар	Матад, Эрдэнэцагаан	Тэргүүн баян сум	Вүүдстар ресорсес интернэшнл ХХК
8	XV-012416	2007.04.18	Баян-Өлгий	Алтанцөгц	Баянбулаг	Геосан ХХК
9	MV-005648	2003.04.19	Дархан-Уул	Шарын гол	Шаазгайн гозгор	Гуравт ХХК
10	XV-017012	2006.03.28	Баян-Өлгий	Ногооннуур	Бахлаг	Монголиандаймонд майнинг ХХК
11	XV-020075	2016.03.30	Дорноговь	Сайншанд	Сэнж	Дафенг шүн ХХК
12	XV-014063	2008.08.27	Говь-Алтай	Тайшир	Алтангадас	Аз макс ХХК
13	MV-020492	2016.03.25	Төв	Баян	Өндөр	Эрдэнийн цахирмаа тал ХХК
9	XV-020125	2016.01.13	Баян-Өлгий	Буянт	Буянт	Юбиксолюшн ХХК
10	XV-019834	2016.01.14	Дорноговь	Улаанбадрах	Оюу	Элмос ХХК
11	XV-019795	2016.02.03	Баян-Өлгий	Бугат	Овгор	Заамар гоулд ХХК

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

RADO.COM
RADO
AUTOMATIC
SWISS MADE
RADO CENTRIX AUTOMATIC OPEN HEART
HIGH-TECH CERAMIC ELEMENTS. SEAMLESS DESIGN.
RADO
SWITZERLAND
TIME IS THE ESSENCE WE ARE MADE OF
SWISS WATCH SHOP I, НАРАН МОЛЛ, 2-Р ДАВХАР, СӨҮЛИЙН ГУДАМЖ, УТАС: 88115117
SWISS WATCH SHOP II, НАРАН ЦЕНТР, УИД-Н БАРУУН ТАЛД, УТАС: 80087692